



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/782

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж батлах” 11/02, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 162 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Алагтолгой багийн иргэн С.Бадампүрэвийн гэр бүлд төрсөн 3 ихэр хүүхдийг эрүүл саруул өсгөн бойжуулахад дэмжлэг болгож орон сууц худалдан авахад нь зориулан 80 000 000 төгрөг/наян сая/-ийг олгосугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 80 000 000 сая төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтаас зарцуулахыг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ